# ГАРЧИГ

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ


| | | | |
|---|---|---|---|
| 10. | Үндсэн хуулийн цэцийн 2014 оны 07 дугаар дүгнэлтийн тухай | Дугаар 81 | 14 |
| 11. | Санхүүгийн зохицуулах хорооны дарга, зарим гишүүнийг чөлөөлөх тухай | Дугаар 82 | 14 |
| 12. | Санхүүгийн зохицуулах хорооны дарга, зарим гишүүнийг томилох тухай | Дугаар 83 | 15 |
| 13. | Монголын Үндэсний олон нийтийн радио, телевизийн Үндэсний зөвлөлийн гишүүнээс чөлөөлөх тухай | Дугаар 84 | 15 |
| 14. | Монголын Үндэсний олон нийтийн радио, телевизийн Үндэсний зөвлөлийн гишүүнээр томилох тухай | Дугаар 85 | 16 |
| 15. | Зарим Байнгын хорооны дарга нарыг сонгох, чөлөөлөх тухай | Дугаар 86 | 16 |
| 16. | Байнгын хороодын бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай | Дугаар 87 | 17 |
| 17. | Хүний эрхийн дэд хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай | Дугаар 88 | 18 |


## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ


| | | | |
|---|---|---|---|
| 18. | Хүүхдийн спортын Ү их наадам зохион байгуулах тухай | Дугаар 359 | 19 |
| 19. | Санхүүжилт олгох тухай | Дугаар 360 | 20 |
| 20. | Журам батлах тухай | Дугаар 374 | 20 |
| 21. | Журам батлах тухай | Дугаар 384 | 26 |
| 22. | Монгол Улсын гурван сая дахь иргэнийг тодорхойлох, алдаршуулах тухай | Дугаар 400 | 53 |

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2014 оны 12 дугаар сарын 19-ний өдөр | Дугаар 81 | Улаанбаатар хот

**Үндсэн хуулийн цэцийн 2014 оны 07 дугаар дүгнэлтийн тухай**

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.4 дэх заалтыг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2014 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн 07 дугаар дүгнэлтийн 1 дэх заалтын “Шүүх байгуулах тухай хуулийн 1 дүгээр зүйлийн Нэг.Иргэний хэргийн давж заалдах шатны шүүх, Хоёр.Эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүх; мөн хуулийн 2 дугаар зүйлийн Нэг.Дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүх, Хоёр. Дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүх, Гурав.Захиргааны хэргийн анхан шатны шүүх гэсний 6, 11 дэх заалт нь Монгол Улсын Үндсэн хуулийн Дөчин наймдугаар зүйлийн 1 дэх хэсгийн “Шүүхийн үндсэн тогтолцоо … аймаг, нийслэлийн шүүх, … дүүргийн шүүхээс бүрдэх …” гэснийг зөрчсөн байна.” гэснийг хүлээн зөвшөөрөх боломжгүй гэж үзсүгэй.

2.Энэ тогтоолыг 2014 оны 12 дугаар сарын 19-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА З.ЭНХБОЛД**

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2014 оны 12 дугаар сарын 25-ны өдөр | Дугаар 82 | Улаанбаатар хот

**Санхүүгийн зохицуулах хорооны дарга, зарим гишүүнийг чөлөөлөх тухай**

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.3 дахь заалт, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.2 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Дашдондовын Баярсайханыг Санхүүгийн зохицуулах хорооны даргын, Гаравдэмбэрэлийн Хэрлэн, Базархүүгийн Даажамба нарыг орон тооны гишүүний, Бядрангийн Лхагвасүрэн, Балганы Батбаяр нарыг орон тооны бус гишүүний үүрэгт ажлаас тус тус чөлөөлсүгэй.

2.Энэ тогтоолыг 2014 оны 12 дугаар сарын 25-ны өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН**
**ИХ ХУРЛЫН ДАРГА З.ЭНХБОЛД**

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2014 оны 12 дугаар сарын 25-ны өдөр | Дугаар 83 | Улаанбаатар хот

### Санхүүгийн зохицуулах хорооны дарга, зарим гишүүнийг томилох тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.2 дахь хэсэг, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.2 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Санхүүгийн зохицуулах хорооны даргаар Загдхүүгийн Нарантуяаг, орон тооны гишүүнээр Харьюугийн Бум-Эрдэнэ, Эрдэнэбилэгийн Батболд, орон тооны бус гишүүнээр Данжилаагийн Ганбат, Жалцангийн Цэдэнрагчаа нарыг тус тус томилсугай.

2.Энэ тогтоолыг 2014 оны 12 дугаар сарын 25-ны өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН**
**ИХ ХУРЛЫН ДАРГА З.ЭНХБОЛД**

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2014 оны 12 дугаар сарын 25-ны өдөр | Дугаар 84 | Улаанбаатар хот

### Монголын Үндэсний олон нийтийн радио, телевизийн Үндэсний зөвлөлийн гишүүнээс чөлөөлөх тухай

Олон нийтийн радио, телевизийн тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Монголын Үндэсний олон нийтийн радио, телевизийн Үндэсний зөвлөлийн гишүүнээс Шагдарын Батцэцэг, Баасанжавын Ганболд,

Дамбын Гантөмөр, Цэрэнпилийн Гомбосүрэн, Чойжилжавын Дамбажав, Цэрэнчимэдийн Зоригтбаатар, Сүрэнгийн Цэрэндорж нарыг чөлөөлсүгэй.

2.Энэ тогтоолыг 2015 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН**
**ИХ ХУРЛЫН ДАРГА З.ЭНХБОЛД**

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2014 оны 12 дугаар сарын 25-ны өдөр Дугаар 85 Улаанбаатар хот

### Монголын Үндэсний олон нийтийн радио, телевизийн Үндэсний зөвлөлийн гишүүнээр томилох тухай

Олон нийтийн радио, телевизийн тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.8 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Монголын Үндэсний олон нийтийн радио, телевизийн Үндэсний зөвлөлийн гишүүнээр Батжаргалын Батбаяр, Баастын Золбаяр, Дэндэвийн Нямсамбуу, Дэшигрэнцэнгийн Оюун-Эрдэнэ, Довдонгийн Цэндсүрэн, Балдангийн Энхмандах, Зургаанжингийн Энхболд нарыг томилсугай.

2.Энэ тогтоолыг 2015 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН**
**ИХ ХУРЛЫН ДАРГА З.ЭНХБОЛД**

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2014 оны 12 дугаар сарын 25-ны өдөр Дугаар 86 Улаанбаатар хот

### Зарим Байнгын хорооны дарга нарыг сонгох, чөлөөлөх тухай

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.3, 22.4 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны даргаар Улсын Их Хурлын гишүүн Жадамбын Энхбаяр, Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны даргаар Улсын Их Хурлын гишүүн Сундуйн Батболд, Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хорооны даргаар Улсын Их Хурлын гишүүн Догсомын Батцогт, Төрийн байгуулалтын байнгын хорооны даргаар Улсын Их Хурлын гишүүн Агыпарын Бакей, Төсвийн байнгын хорооны даргаар Улсын Их Хурлын гишүүн Баярбаатарын Болор, Эдийн засгийн байнгын хорооны даргаар Улсын Их Хурлын гишүүн Жамъянсүрэнгийн Батсуурь нарыг тус тус сонгосугай.

2.Улсын Их Хурлын гишүүн Цэрэндашийн Оюунбаатарыг Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны даргын, Улсын Их Хурлын гишүүн Гарьдхүүгийн Баярсайханыг Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны даргын, Улсын Их Хурлын гишүүн Цэрэнпилийн Даваасүрэнг Төсвийн байнгын хорооны даргын, Улсын Их Хурлын гишүүн Батхүүгийн Гарамгайбаатарыг Эдийн засгийн байнгын хорооны даргын үүрэгт ажлаас тус тус чөлөөлсүгэй.

3.Энэ тогтоолыг 2014 оны 12 дугаар сарын 25-ны өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН**
**ИХ ХУРЛЫН ДАРГА З.ЭНХБОЛД**

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2014 оны 12 дугаар сарын 26-ны өдөр | Дугаар 87 | Улаанбаатар хот

**Байнгын хороодын бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай**

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.7 дахь заалт, 22 дугаар зүйлийн 22.1 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.3 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Улсын Их Хурлын гишүүн Ёндонгийн Отгонбаярыг Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны, Улсын Их Хурлын гишүүн Отгонбилэгийн Содбилэг, Цэрэндашийн Цолмон, Жаргалтулгын Эрдэнэбат нарыг Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны, Улсын Их Хурлын гишүүн Жамъянсүрэнгийн Батсуурийг Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хорооны, Улсын Их Хурлын

гишүүн Долгорсүрэнгийн Сумъяабазар, Баттогтохын Чойжилсүрэн нарыг Өргөдлийн байнгын хорооны, Улсын Их Хурлын гишүүн Чимэдийн Хүрэлбаатар, Раднаагийн Бурмаа, Дондогдоржийн Эрдэнэбат нарыг Төрийн байгуулалтын байнгын хорооны, Улсын Их Хурлын гишүүн Сангажавын Баярцогт, Дамдингийн Хаянхярваа нарыг Төсвийн байнгын хорооны, Улсын Их Хурлын гишүүн Нямтайширын Номтойбаяр, Дуламсүрэнгийн Оюунхорол нарыг Хууль зүйн байнгын хорооны бүрэлдэхүүнээс тус тус чөлөөлсүгэй.

2.Улсын Их Хурлын гишүүн Отгонбилэгийн Содбилэгийг Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны, Улсын Их Хурлын гишүүн Нямтайширын Номтойбаяр, Санжаасүрэнгийн Оюун, Чимэдийн Хүрэлбаатар нарыг Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны, Улсын Их Хурлын гишүүн Долгорсүрэнгийн Сумъяабазарыг Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хорооны, Улсын Их Хурлын гишүүн Дашжамцын Арвин, Жамъянсүрэнгийн Батсуурь, Дамдингийн Хаянхярваа нарыг Өргөдлийн байнгын хорооны, Улсын Их Хурлын гишүүн Нямжавын Батбаяр, Хишигдэмбэрэлийн Тэмүүжин, Отгонбилэгийн Содбилэг нарыг Төрийн байгуулалтын байнгын хорооны, Улсын Их Хурлын гишүүн Ядамсүрэнгийн Санжмятав, Баттогтохын Чойжилсүрэн нарыг Төсвийн байнгын хорооны, Улсын Их Хурлын гишүүн Сандагийн Бямбацогт, Ёндонгийн Отгонбаяр нарыг Хууль зүйн байнгын хорооны гишүүнээр тус тус баталсугай.

3.Энэ тогтоолыг 2014 оны 12 дугаар сарын 26-ны өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН**
**ИХ ХУРЛЫН ДАРГА З.ЭНХБОЛД**

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2014 оны 12 дугаар сарын 26-ны өдөр — Дугаар 88 — Улаанбаатар хот

### Хүний эрхийн дэд хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.7 дахь заалт, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4 дэх хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Улсын Их Хурлын гишүүн Ёндонгийн Отгонбаяр, Цэрэндашийн Оюунбаатар нарыг Хүний эрхийн дэд хорооны гишүүнээр баталсугай.

2.Энэ тогтоолыг 2014 оны 12 дугаар сарын 26-ны өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН**
**ИХ ХУРЛЫН ДАРГА З.ЭНХБОЛД**

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2014 оны 11 дүгээр сарын 21-ний өдөр — Дугаар 359 — Улаанбаатар хот

**Хүүхдийн спортын Ү их наадам зохион байгуулах тухай**

Биеийн тамир, спортын тухай хуулийн 7.1.5, 16.1, 20.3-ыг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Хүүхдийн спортын Ү их наадмыг 2015 онд орон даяар зохион байгуулахыг Соёл, спорт, аялал жуулчлалын сайдын үүрэг гүйцэтгэгч Ц.Оюунгэрэл, Боловсрол, шинжлэх ухааны сайдын үүрэг гүйцэтгэгч Л.Гантөмөр, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгасугай.

2. Их наадам болон эрх авах тэмцээнд оролцох зардлыг 2015 оны төсөвтөө тусган санхүүжүүлэхийг аймаг, нийслэл, дүүргийн Засаг дарга нарт даалгасугай.

3. Их наадмыг зохион байгуулахад шаардагдах хөрөнгийг Соёл, спорт, аялал жуулчлалын сайдын 2015 оны төсвийн багцад тусган санхүүжүүлэхийг Сангийн сайд, Соёл, спорт, аялал жуулчлалын сайд нарт тус тус даалгасугай.

4. Хүүхдийн спортын Ү их наадмыг өндөр хэмжээнд зохион байгуулж, дүнг 2015 оны IY улиралд багтаан Засгийн газарт танилцуулахыг Соёл, спорт, аялал жуулчлалын сайд, Боловсрол, шинжлэх ухааны сайд нарт тус тус даалгасугай.

**МОНГОЛ УЛСЫН**
**ЕРӨНХИЙ САЙД Ч.САЙХАНБИЛЭГ**

**СОЁЛ, СПОРТ, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН**
**САЙДЫН ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭГЧ Ц.ОЮУНГЭРЭЛ**

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2014 оны 11 дүгээр сарын 21-ний өдөр | Дугаар 360 | Улаанбаатар хот

**Санхүүжилт олгох тухай**

Улсын Их Хурлын 2012 оны 52 дугаар тогтоол, Засгийн газрын 2014 оны 176 дугаар тогтоолыг тус тус үндэслэн, Засгийн газрын 2012-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх зорилгоор Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Экспортыг дэмжих, импортыг орлох дотоодын үйлдвэрлэл болон жижиг, дунд үйлдвэрийн 2 тэрбум төгрөгөөс илүүгүй санхүүжилт хүссэн төслийн эх үүсвэрт шаардагдах 37.4 (гучин долоон тэрбум дөрвөн зуун сая) тэрбум төгрөгийг Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангийн эргэн төлөлтөөс төвлөрүүлсэн хөрөнгөөс холбогдох хууль тогтоомж, “Жижиг, дунд үйлдвэрийг дэмжих зорилгоор хөнгөлөлттэй зээл олгох журам”-ын дагуу санхүүжүүлэхийг Хөдөлмөрийн сайдын үүрэг гүйцэтгэгч Я.Санжмятавт зөвшөөрсүгэй.

2. Энэ тогтоолын 1 дүгээр зүйлд заасан ажлыг хэрэгжүүлэх арга хэмжээг авч, хяналт тавьж ажиллах, 2014-2015 оны төсвийн тодотголд оруулж батлуулахыг Монгол Улсын Ерөнхий сайд, Сангийн сайдын үүрэг гүйцэтгэгч Ч.Сайханбилэг, Хөдөлмөрийн сайдын үүрэг гүйцэтгэгч Я.Санжмятав нарт тус тус даалгасугай.

**МОНГОЛ УЛСЫН**
**ЕРӨНХИЙ САЙД** **Ч.САЙХАНБИЛЭГ**

**ХӨДӨЛМӨРИЙН САЙДЫН**
**ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭГЧ** **Я.САНЖМЯТАВ**

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2014 оны 11 дүгээр сарын 26-ны өдөр | Дугаар 374 | Улаанбаатар хот

**Журам батлах тухай**

Инновацийн тухай хуулийн 6.1.5, 27.2-т заасныг тус тус үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. “Эрдэм шинжилгээний байгууллагын дэргэд гарааны компани байгуулах журам”-ыг хавсралт ёсоор баталсугай.

2. Энэ журмын хэрэгжилтийг зохион байгуулан хяналт тавьж ажиллахыг Боловсрол, шинжлэх ухааны сайдын үүрэг гүйцэтгэгч Л.Гантөмөрт үүрэг болгосугай.

**МОНГОЛ УЛСЫН**
**ЕРӨНХИЙ САЙД** **Ч.САЙХАНБИЛЭГ**

**БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ**
**САЙДЫН ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭГЧ** **Л.ГАНТӨМӨР**

Засгийн газрын 2014 оны 374 дүгээр
тогтоолын хавсралт

ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ БАЙГУУЛЛАГЫН ДЭРГЭД
ГАРААНЫ КОМПАНИ БАЙГУУЛАХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэхүү журмын зорилго нь эрдэм шинжилгээний байгууллагын дэргэд гарааны компани байгуулах, бүртгүүлэх үндсэн зарчмыг тогтоох, түүнтэй холбогдон үүсэх харилцааг зохицуулахад оршино.

1.2. Энэ журмын 1.1-д заасан эрдэм шинжилгээний байгууллага гэдэгт Шинжлэх ухаан, технологийн тухай хуулийн 11.2.1, 11.2.2, 11.2.3 дахь заалтад заасан байгууллагуудыг хамааруулна.

1.3. Гарааны компанийн шинжлэх ухаан, технологийн туршин нэвтрүүлэх үйл ажиллагааг Шинжлэх ухаан, технологийн тухай хуулиар, инновацийн бүтээгдэхүүний үйлдвэрлэлтэй холбогдсон харилцааг Инновацийн тухай хууль, компани байгуулах, өөрчлөх, татан буулгах, удирдлага зохион байгуулалт, хяналтын бүтэц, хувьцаа эзэмшигчдийн эрх, үүрэгтэй холбоотой харилцааг Компанийн тухай хууль болон бусад холбогдох хуулиар зохицуулна.

1.4. Энэхүү журамд хэрэглэсэн дараах нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно:

1.4.1. “инновацийн төсөл” гэж Инновацийн тухай хуулийн 3.1.6-д заасныг;

1.4.2. “гарааны компани” гэж Инновацийн тухай хуулийн 3.1.8-д заасныг;

1.4.3. "инновацийн төсөл санаачлагч" (цаашид "төсөл санаачлагч" гэх) гэж оюуны өмчийг эдийн засгийн эргэлтэд оруулах зорилгоор инновацийн төсөл санаачлан боловсруулж хэрэгжүүлэхээр хүсэлт гаргасан иргэнийг.

1.5. Инновацийн төсөл хэрэгжүүлэх хугацаа 3 хүртэл жил байна.

1.6. Инновацийн төслийн үр дүнд бий болох бүтээгдэхүүний технологийн туршилт боловсруулалтын ажлын онцлог, үр дүнгийн баталгаажилтаас хамаарч төсөл хэрэгжүүлэх хугацааг нэг удаа 2 хүртэлх жилээр сунгаж болно. Эрдэм шинжилгээний байгууллага инновацийн төсөл хэрэгжүүлэх хугацаа дуусахаас 1 сарын өмнө инновацийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагад хугацааг сунгуулах тухай хүсэлтээ гаргана.

Хоёр. Инновацийн төслийг бүртгүүлэх

2.1. Төсөл санаачлагч нь гарааны компани байгуулах зорилгоор боловсруулсан инновацийн төсөл бүртгүүлэх хүсэлтийг оюуны өмчийн эрх эзэмшигч эрдэм шинжилгээний байгууллагын Эрдмийн зөвлөлд гаргана.

2.2. Төсөл санаачлагчийн нэр дээр өмчлөлтэй байгаа оюуны өмчийг тухайн эрдэм шинжилгээний байгууллага дээр хэрэгжсэн төслийн үр дүнд боловсруулсан бол төсөл санаачлагчийн хүсэлтийг харгалзан гарааны компани байгуулан инновацийн төсөл хэрэгжүүлж болно.

2.3. Инновацийн төсөл нь Инновацийн тухай хуулийн 14.1-д заасан дараах шаардлагыг хангасан байна:

2.3.1. инновацийг бий болгох нэгдсэн зорилго бүхий саналыг агуулсан байх;

2.3.2. хэрэгжүүлэх гэж байгаа төслийн давтагдаагүй байдал болон оюуны өмчийн эрхийн баталгаажилтыг нотолсон байх;

2.3.3. инновацийн төслийн техник, эдийн засгийн үндэслэл болон үр ашгийн тооцоог хийсэн байх;

2.3.4. инновацийн төсөл хэрэгжүүлэх хүний нөөц бүрдүүлсэн байх.

2.4. Инновацийн төсөл хэрэгжсэнээр бий болох бүтээгдэхүүн нь Инновацийн тухай хуулийн 15.1-д заасан шаардлагыг хангасан байна.

2.5. Инновацийн төсөл санаачлагч дор дурдсан бичиг баримтыг бүрдүүлэн энэ журмын 2.1-д заасан байгууллагын Эрдмийн зөвлөлд хүргүүлнэ:

2.5.1. гарааны компани байгуулах үндэслэл бүхий хүсэлт;

2.5.2. энэ журмын 2.3-т заасан шаардлага хангасан инновацийн төсөл.

2.6. Эрдмийн зөвлөл гарааны компани байгуулах инновацийн төслийг сонгохдоо Инновацийн тухай хуулийн 14.1-ийг удирдлага болгоно.

2.7. Эрдэм шинжилгээний байгууллага нь сонгосон инновацийн төслийг бүртгүүлэхдээ дор дурдсан баримт бичгийг бүрдүүлэн инновацийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ:

2.7.1. инновацийн төслийг хэрэгжүүлэхээр шийдвэрлэсэн тухай Эрдмийн зөвлөлийн тодорхойлолт;

2.7.2. төсөл санаачлагчаас ирүүлсэн инновацийн төсөл.

2.8. Инновацийн тухай хуулийн 15.2-т заасны дагуу инновацийн бүтээгдэхүүн энэ хуульд заасан шаардлагад нийцэж байгаа эсэх талаарх дүгнэлтийг инновацийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага шинжээчдийн дүгнэлтэд үндэслэн гаргана.

2.9. Инновацийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага инновацийн төсөл нь Инновацийн тухай хуулийн 14 дүгээр зүйлд тавигдах шаардлагыг хангасан тохиолдолд хүсэлт гаргасан өдрөөс хойш 14 хоногт багтаан бүртгэж, нэгдсэн мэдээллийн санд оруулна.

2.10. Инновацийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага төслийг бүртгэсэн талаар эрдэм шинжилгээний байгууллагад албан бичгээр хариу мэдэгдэнэ.

Гурав. Гарааны компани байгуулах

3.1. Энэ журмын 2.9-т заасны дагуу бүртгэгдсэн инновацийн төслийн санаачлагч инновацийн төсөл хэрэгжүүлэх зорилго бүхий хуулийн этгээдийг Компанийн тухай хуульд заасны дагуу байгуулна.

3.2. Эрдэм шинжилгээний байгууллага нь шинээр байгуулагдсан гарааны компанийн талаарх мэдээллийг инновацийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ.

3.3. Инновацийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага нь шинээр улсын бүртгэлд бүртгэгдсэн гараааны компанийн талаар татвар, гааль, хөдөлмөр, иргэний бүртгэл, иргэний харьяалал, шилжилт хөдөлгөөн, гадаадын хөрөнгө оруулалт болон газрын харилцааны асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад албан бичгээр мэдэгдэнэ.

3.4. Энэ журмын дагуу байгуулагдсан компани нь Инновацийн тухай хууль болон бусад хууль тогтоомжид заагдсан хөнгөлөлт, дэмжлэгийг эдэлнэ.

3.5. Гарааны компани нь энэ журмын 2.1-д заасан эрдэм шинжилгээний байгууллагатай лицензийн гэрээг байгуулах бөгөөд лицензийн гэрээг Оюуны өмчийн газарт бүртгүүлнэ. Лицензийн гэрээтэй холбогдон үүсэх харилцааг Патентийн тухай хуулийн дагуу шийдвэрлэнэ.

3.6. Гарааны компанийг үүсгэн байгуулагч нь хуулийн этгээд үүсгэн байгуулах гэрээ байгуулна. Энэхүү гэрээнд хамтарч ажиллах зарчим, хүлээх үүрэг, дүрмийн сан бүрдүүлэх, оюуны өмчийг эзэмших, ашиглах, технологийн нууцлалыг хадгалах зэрэг асуудлыг тохиролцон тусгасан байна.

3.7. Гарааны компанийн үүсгэн байгуулагч нь компанийн үйл ажиллагаанд ашиглах оюуны өмчийг эрх бүхий мэргэжлийн байгууллагаар үнэлүүлж, эрдэм шинжилгээний байгууллагын үндсэн хөрөнгийн эргэлтийн бус хөрөнгөд бүртгүүлсэн байна.

3.8. Эрдэм шинжилгээний байгууллага нь гарааны компанийн дүрмийн санг бүрдүүлэхэд Инновацийн тухай хуулийн 27.3-т заасны дагуу оролцож болно.

3.9. Гарааны компани Төлөөлөн удирдах зөвлөл (цаашид “Удирдах зөвлөл” гэх)-тэй байна. Компанийн үүсгэн байгуулагч нь дүрмийн санд оруулсан хөрөнгийн хувь хэмжээгээр Удирдах зөвлөлд төлөөллөө оруулна. Эрдэм шинжилгээний байгууллагыг төлөөлөх гишүүнийг Эрдмийн зөвлөл томилно.

3.10. Төсөл санаачлагч нь гарааны компанид удирдах албан тушаал эрхэлж болох бөгөөд энэ тухай эрдэм шинжилгээний байгууллагын дотоод журамд тусгасан байвал зохино.

3.11. Эрдэм шинжилгээний байгууллага нь гарааны компанид бойжуулах технологийг туршин зүгшрүүлэхэд эрдэм шинжилгээ, лаборатори, туршилт-судалгааны чиглэлээр шаардлагатай дэмжлэг,

туслалцааг үзүүлнэ. Эрдэм шинжилгээний байгууллага нь гарааны компанид байр, интернет сүлжээ зэрэг дэд бүтцийг хөнгөлөлттэй нөхцөлөөр ашиглуулж болно.

Дөрөв. Гарааны компанийн үйл ажиллагааг дуусгавар болгох

4.1. Эрдэм шинжилгээний байгууллагын дэргэд байгуулсан гарааны компанийн үйл ажиллагаа, инновацийн төслийн хэрэгжилтийн явц, үр дүнг Эрдмийн зөвлөл хагас жил тутам хэлэлцэнэ.

4.2. Байгуулагдсанаас хойш 1 жилийн хугацаанд инновацийн туршилтын үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлээгүй буюу эрхлэх боломжгүй болохыг Эрдмийн зөвлөл тогтоосон тохиолдолд эрдэм шинжилгээний байгууллага компанийн үүсгэн байгуулагчидтай зөвшилцсөний үндсэн дээр гарааны компанийн хэрэгжүүлж байгаа төслийг зогсоох хүсэлтийг инновацийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагад гаргаж болно.

4.3. Инновацийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага нь энэ журмын 4.2-т заасан хүсэлтийг судлан зохих шийдвэр гарган 14 хоногт багтаан эрдэм шинжилгээний байгууллагад хариу мэдэгдэнэ.

4.4. Инновацийн төсөл хэрэгжүүлэх хугацаа дууссан тохиолдолд гарааны компанийн үйл ажиллагааг үргэлжлүүлэх эсэх асуудлыг компанийн үүсгэн байгуулагч эсхүл хувьцаа эзэмшигч шийдвэрлэнэ.

4.5. Гарааны компанийн үйл ажиллагааны явцад бий болсон эд хөрөнгөд Инновацийн тухай хуулийн 17.1.3-т заасны дагуу түргэвчилсэн элэгдэл хорогдол тооцно.

Тав. Бусад

5.1. Гарааны компанийн үйл ажиллагааны мэдээллийн нууцлалыг хадгалах, хамгаалах, ашиглахтай холбогдсон харилцааг Төрийн нууцын тухай, Байгууллагын нууцын тухай, Хувь хүний нууцын тухай хуульд заасны дагуу зохицуулна.

5.2. Мэдээллийн нууцыг хадгалах, хууль бус эзэмшлээс сэргийлэхтэй холбоотой хариуцлага, эрх, үүргийн талаар гарааны компанийг үүсгэн байгуулагч талууд гэрээгээр нарийвчлан тогтооно.

# МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2014 оны 12 дугаар сарын 15-ны өдөр | Дугаар 384 | Улаанбаатар хот

**Журам батлах тухай**

Шилэн дансны тухай хуулийн 5.4, Засгийн газрын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 1 дэх хэсгийг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. “Шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох тухай журам”-ыг хавсралт ёсоор баталсугай.

2. Энэ тогтоолын 1 дүгээр зүйлээр баталсан журмыг хэрэгжүүлж ажиллахыг төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд, төрийн өмчит үйлдвэрийн газар, хяналтын багц буюу түүнээс дээш хэмжээний хувьцааг нь төр, орон нутаг болон тэдгээрийн нэгдмэл сонирхолтой этгээд эзэмшиж байгаа компани, улс, орон нутгийн төсвийн хөрөнгөөр хөрөнгө оруулалт, төсөл, хөтөлбөр, арга хэмжээ, ажил, үйлчилгээ гүйцэтгэж байгаа аж ахуйн нэгж, байгууллага болон хууль тогтоомжийн дагуу гэрээний үндсэн дээр төрийн чиг үүргийг хэрэгжүүлж байгаа гүйцэтгэгч нарт үүрэг болгосугай.

3. Энэ тогтоол гарсантай холбогдуулан “Журам батлах тухай” Засгийн газрын 2012 оны 1 дүгээр сарын 18-ны өдрийн 17 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД Ч.САЙХАНБИЛЭГ**

**САНГИЙН САЙД Ж.ЭРДЭНЭБАТ**

Засгийн газрын 2014 оны 384 дүгээр тогтоолын хавсралт

## ШИЛЭН ДАНСНЫ ЦАХИМ ХУУДСАНД ТАВИГДАХ МЭДЭЭЛЛИЙН АГУУЛГА, НИЙТЛЭГ СТАНДАРТЫГ ТОГТООХ ТУХАЙ ЖУРАМ

### Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэхүү журмын зорилго нь Шилэн дансны тухай хууль (цаашид “хууль” гэх)-ийн 3.1-д заасан байгууллага хуульд заасан мэдээллийг нийтэд ил тод мэдээлэх нийтлэг стандарт, агуулгыг тогтоох, түүнтэй холбоотой харилцааг зохицуулахад оршино.

1.2. Шилэн дансны тухай хуулийн 3.3-т заасан төрийн нууцад хамаарах төсөв, үндэсний аюулгүй байдлыг хангахтай холбогдсон гүйцэтгэх ажил эрхлэх эрх бүхий байгууллагын гүйцэтгэх ажилтай холбоотой төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, хэрэгжилт, тайлагнал энэ журамд хамаарахгүй.

Хоёр. Журмын нэр томъёоны тодорхойлолт

2.1. Энэ журамд хэрэглэсэн дараах нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно:

2.1.1. "PDF, Excel форматаар мэдээллийг олон нийтэд мэдээлнэ" гэж заасан тодорхой маягтын дагуу шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд хуулж оруулахыг;

2.1.2. "Excel, XML форматаар мэдээллийг олон нийтэд мэдээлнэ" гэж заасан тодорхой маягтын дагуу шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд хөрвүүлж оруулахыг;

2.1.3. "Цахимаар мэдээллийг оруулна" гэж заасан тодорхой маягтын дагуу шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд тайлангийн мэдээллийг шивж оруулахыг.

Гурав. Мэдээллийг олон нийтэд түгээхэд баримтлах зарчим

3.1. Мэдээллийг нийтэд нээлттэй байлгах зорилгоор боломжтой бүх хэлбэрийг ашиглана.

3.2. Мэдээлэл нь Төсвийн тухай хууль, Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, Шилэн дансны тухай хуульд нийцсэн байна.

3.3. Энэ журмын 1.1-д заасан байгууллага өөрийн цахим хуудсанд шилэн дансны мэдээллийн цэстэй байна. Энэ журмын 3.3-т заасан цэс нь төсөв/гүйцэтгэл, хөрөнгө оруулалт, тендер болон худалдан авалт, үнэт цаас, байгууллага гэсэн 5 дэд цэстэй байна.

3.4. Байгууллага өөрийн цахим хуудсанд мэдээллийг дараах дэд цэсний дагуу ангилан зохион байгуулна:

3.4.1. Төсөв/гүйцэтгэл:

- Төсвийн захирагчийн гүйцэтгэлийг хэмжих тоон болон чанарын шалгуур үзүүлэлт, хүрсэн үр дүн

- Төсвийн гүйцэтгэлийг батлагдсан төсвийн төлөвлөгөөтэй харьцуулсан үзүүлэлт

- Өмнөх оны төсвийн зарлагын хэмнэлт, туслах үйл ажиллагааны орлогоос давсан хэсгийг урамшуулалд зарцуулсан бол зориулалтыг заасан байх

- Төсвийн ерөнхийлөн захирагчийн хуулийн 6.2.1-д тодорхойлсон үзүүлэлт, хүрсэн үр дүн, хэрэгжилтийг хэмжих тоон болон чанарын үзүүлэлт

- Төрийн өмчит хуулийн этгээдийн эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин

3.4.2. Хөрөнгө оруулалт:

- Хөрөнгийн болон концессын зүйлийн зарлага, санхүүжилтийг төсөл, обьект тус бүрээр

- Орон нутгийн болон улсын төсөвт төвлөрүүлэх орлого, түүний задаргаа

- Орон нутгийн хөгжлийн сангийн гүйцэтгэл

3.4.3. Тендер, худалдан авалт:

- Тендерийн баримт бичиг, тендер шалгаруулалтыг явуулах журам, тендерийн урилга, тендерт оролцохыг сонирхогчдод тавих шалгуур үзүүлэлт, тендерт шалгарсан болон шалгараагүй оролцогчийн талаарх товч мэдээлэл, хуулийн үндэслэл, шалтгаан

- 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авалтын бараа, ажил, үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг

- Улс болон орон нутгийн төсвийн хөрөнгөөр 10 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий хөрөнгө оруулалт, төсөл, хөтөлбөр, арга хэмжээ, ажил, үйлчилгээ гүйцэтгэж байгаа аж ахуйн нэгж нийт төсөвт өртөг, хэрэгжилтийн явц, үе шат, зарлага, санхүүжилтийн мэдээлэл

3.4.4. Үнэт цаас:

- Засгийн газрын дотоод үнэт цаасны талаарх мэдээлэл
- Засгийн газрын гадаад, дотоод өрийн талаарх мэдээлэл
- Төсвийн алдагдлыг санхүүжүүлэх зорилгоор гаргасан Засгийн газрын дотоод үнэт цаасны талаарх мэдээлэл
- Хуулийн 6.5.8, 6.5.9, 6.5.10-т заасны дагуу гаргах концессын мэдээлэл

3.4.5. Байгууллага:

- Хандив, тусламжийн хэмжээ, түүний зарцуулалт
- Байгууллагын өмч хөрөнгө, мөнгө зарцуулах, өр авлага, зарлага, худалдан авах үйл ажиллагаатай холбоотой шийдвэр
- Нийгмийн даатгалын сангаас олгосон тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн талаарх мэдээлэл
- Хуулийн 3.1.3-т заасан хуулийн этгээдээс байгуулсан их хэмжээний хэлцлийн талаарх мэдээлэл

3.5. Мэдээллийг тогтмол шинэчилж, өөрчлөлт орсон тухай бүр өмнөх мэдээллийг цахим хуудасны архивт хадгалан, архивын мэдээллийн санд нэвтрэх, татаж авах, хэвлэх боломжийг хангасан байна.

## Дөрөв. Төрийн байгууллага, албан газрын тавих мэдээллийн агуулга, хэлбэр

4.1. Хуулийн 3.1.1-д заасан төрийн байгууллага, албан газар дараах агуулга бүхий мэдээллийг дор дурдсан хэлбэрээр тогтоосон хугацаанд нийтэд мэдээлнэ:

4.1.1. төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаарх тоон болон чанарын үзүүлэлтийг жил бүрийн 1 дүгээр сарын 10-ны дотор энэхүү журмын 1 дүгээр хавсралтад заасан маягтын дагуу PDF, Excel, XML форматаар;

4.1.2. тухайн жилийн төсөв, орлого, урсгал зардал, зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг жил бүрийн 1 дүгээр сарын 10-ны дотор, дараа жилийн төсвийн төслийг жил бүрийн 9 дүгээр сарын 15-ны дотор энэхүү журмын 2 дугаар хавсралтад заасан маягтын дагуу PDF, Excel, XML форматаар;

4.1.3. хөрөнгийн зардал, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, концессын зүйлийн жагсаалтыг жил бүрийн 1 дүгээр сарын 10-ны дотор энэхүү журмын 3 дугаар хавсралтад заасан маягтын дагуу PDF, Excel, XML форматаар;

4.1.4. улсын төсөв болон орон нутгийн төсөвт төвлөрүүлэх орлого, тэдгээрийн задаргааг жил бүрийн 1 дүгээр сарын 10-ны дотор энэхүү журмын 4 дүгээр хавсралтад заасан маягтын дагуу PDF, Excel, XML форматаар;

4.1.5. төсвийн ерөнхийлөн захирагчийн энэ журмын 3.1.1-д тодорхойлсон үзүүлэлт, хүрсэн үр дүн, хэрэгжилтийг хэмжих тоон болон чанарын үзүүлэлтийг хагас жилээр гарган 8 дугаар сарын 15-ны дотор, өмнөх оны гүйцэтгэлийг дараа оны 4 дүгээр сарын 25-ны дотор энэхүү журмын 1 дүгээр хавсралтад заасан маягтын дагуу PDF, Excel, XML форматаар;

4.1.6. төсвийн хагас жилийн гүйцэтгэлийг батлагдсан төсвийн төлөвлөгөөтэй харьцуулан, хэтрэлт, хэмнэлтийн шалтгаан, тайлбарын хамт 8 дугаар сарын 15-ны дотор, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэлийг дараа оны 4 дүгээр сарын 25-ны дотор, сар, улирлын төсвийн гүйцэтгэлийн мэдээг дараа сарын 8-ны дотор энэхүү журмын 2 дугаар хавсралтад заасан маягтын дагуу PDF, Excel, XML форматаар;

4.1.7. өмнөх оны төсвийн зарлагын хэмнэлт, туслах үйл ажиллагааны орлогоос давсан хэсгийг урамшуулалд зарцуулсан хагас жилийн тайланг 8 дугаар сарын 15-ны дотор, жилийн эцсийн тайланг дараа оны 4 дүгээр сарын 25-ны дотор энэхүү журмын 5 дугаар хавсралтад заасан маягтын дагуу PDF, EXCEL, XML форматаар;

4.1.8. хандив, тусламжийн хэмжээ, түүний зарцуулалтын хагас жилийн тайланг 8 дугаар сарын 15-ны дотор, жилийн эцсийн тайланг дараа оны 4 дүгээр сарын 25-ны дотор энэхүү журмын 6 дугаар хавсралтад заасан маягтын дагуу PDF, EXCEL, XML форматаар;

4.1.9. хөрөнгийн болон урсгал зардалд тусгагдсан арга хэмжээг тендер зарлаж сонгон шалгаруулсан бол тендерийн ерөнхий мэдээлэл (тендерийн баримт бичиг, тендер шалгаруулалтыг явуулах

журам, тендерийн урилга, тендерт оролцохыг сонирхогчдод тавих шалгуур үзүүлэлт, тендерт шалгарсан болон шалгараагүй оролцогчийн талаарх товч мэдээлэл, хуулийн үндэслэл, шалтгаан)-ийг тендерийн хорооны дүгнэлт гарснаас хойш 7 хоногийн дотор энэхүү журмын 7 дугаар хавсралтад заасан маягтын дагуу PDF, EXCEL, XML форматаар;

4.1.10. хөрөнгө оруулалтын зарлага, санхүүжилтийг төсөл, обьект тус бүрээр сар бүрийн 8-ны дотор энэхүү журмын 3 дугаар хавсралтад заасан маягтын дагуу PDF, EXCEL, XML форматаар;

4.1.11. 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авалтын бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаягийг 7 хоногийн дотор энэхүү журмын 8 дугаар хавсралтад заасан маягтын дагуу PDF, EXCEL, XML форматаар;

4.1.12. цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэрийн хамт 7 хоногийн дотор энэхүү журмын 9 дүгээр хавсралтад заасан маягтын дагуу цахимаар, PDF, EXCEL, XML форматаар;

4.1.13. бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл болон төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд байгуулсан гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулсан, өр авлага үүсгэсэн аливаа шийдвэрийг гарсан өдрөөс хойш 7 хоногийн дотор энэхүү журмын 10 дугаар хавсралтад заасан маягтын дагуу PDF, EXCEL, XML форматаар;

4.1.14. Засгийн газрын тусгай сангийн батлагдсан төсөв, гүйцэтгэлийн мэдээ, орлого, зарлагын гүйлгээ, худалдан авах үйл ажиллагааг энэхүү журмын 1,2,7,8,9 дүгээр хавсралтад заасан маягтын дагуу PDF, EXCEL, XML форматаар;

4.1.15. Орон нутгийн хөгжлийн сангийн гүйцэтгэлийг арга хэмжээ тус бүрээр сар бүрийн 8-ны дотор энэхүү журмын 11 дүгээр хавсралтад заасан маягтын дагуу цахимаар, PDF, EXCEL, XML форматаар;

4.1.16. тухайн жилийн төсөвт орсон нэмэлт, өөрчлөлтийг энэхүү журмын 2 дугаар хавсралтад заасан маягтын дагуу PDF, Excel, XML форматаар;

4.1.17. жилийн эцсийн санхүүгийн тайланг дараа оны 4 дүгээр сарын 25-ны дотор, хагас жилийн тайланг 8 дугаар сарын 15-ны дотор PDF, Excel, XML форматаар;

4.1.18. хуулийн 6.4.2, 6.4.6, 6.4.7-д заасан мэдээллийг 7 хоногийн дотор, тухайн шийдвэрийн хамт PDF, EXCEL, XML форматаар;

4.2. Санхүү, төсвийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага дараах агуулга бүхий мэдээллийг дор дурдсан хэлбэрээр тогтоосон хугацаанд нийтэд мэдээлнэ:

4.2.1. улсын төсөв, Нийгмийн даатгалын сангийн төсөв, Хүний хөгжил сангийн төсвийн орлого, зарлага, хөрөнгө оруулалт, төсвийн нэгдсэн үзүүлэлтийг хагас жилийн байдлаар 7 дугаар сарын 15-ны дотор, жилийн эцсийн байдлаар дараа оны 1 дүгээр сарын 15-ны дотор, нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн сарын мэдээг дараа сарын 15-ны дотор PDF, EXCEL, XML форматаар;

4.2.2. Засгийн газрын гадаадын зээл, тусламжийн ашиглалтын улирлын мэдээг дараа сарын 15-ны дотор энэхүү журмын 12 дугаар хавсралтад заасан маягтын дагуу PDF, EXCEL, XML форматаар;

4.2.3. Засгийн газрын гадаад, дотоод өрийн улирлын мэдээллийг дараа сарын 15-ны дотор энэхүү журмын 13 дугаар хавсралтад заасан маягтын дагуу PDF, EXCEL, XML форматаар;

4.2.4. төсвийн алдагдал болон хөрөнгө оруулалтыг санхүүжүүлэх зорилгоор гаргасан Засгийн газрын үнэт цаасны талаарх улирлын мэдээллийг дараа сарын 15-ны дотор энэхүү журмын 14 дүгээр хавсралтад заасан маягтын дагуу PDF, EXCEL, XML форматаар;

4.2.5. улсын төсвийн хэмнэлт, хэтрэлт, түүний шалтгааны тайлбарын улирлын мэдээллийг дараа сарын 15-ны дотор, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл болон аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайланг дараа оны 8 дугаар сарын 25-ны дотор PDF, EXCEL, XML форматаар;

4.2.6. хуулийн 6.5.8, 6.5.9, 6.5.10-т заасан мэдээллийг энэхүү журмын 15 дугаар хавсралтад заасан маягтын дагуу PDF, EXCEL, XML форматаар;

4.2.7. улсын төсвийн нэгдсэн үзүүлэлтийг макро эдийн засгийн үзүүлэлт, холбогдох бусад үзүүлэлтүүдтэй уялдуулсан судалгаа, тооцооны улирлын мэдээллийг дараа сарын 15-ны дотор PDF, EXCEL, XML форматаар;

4.3. Нийгмийн даатгалын сангаас олгосон тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн талаарх улирлын мэдээллийг дараа сарын 15-ны дотор хуулийн 6.1-д заасан байгууллага энэхүү журмын 16 дугаар хавсралтад заасан маягтын дагуу PDF, EXCEL, XML форматаар мэдээлнэ.

